Батлав: БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчны бодлого
зохицуулалтын газрын дарга /Г. ЭНХМӨНХ/

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн: “ХОС ХАС ”
ХХК-ийн Гүйцэтгэх захирал /Б.ДӨЛГӨӨН/

# БУЛГАН АЙМГИЙН БҮРЭГХАНГАЙ СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ ОРШИХ “ӨГӨӨМӨР ” АЛТНЫ ШОРООН ОРД АШИГЛАХ" ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

**АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР:**
**MV-008866, MV-001329**

**АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2100231**

ХЯНАСАН: БОАЖЯ-НЫ ХБОБНУГ-ЫН
МЭРГЭЖИЛТЭН

БОЛОВСРУУЛСАН: “ХОС ХАС” ХХК-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН /Х. Буманцэцэг/

# Гарчиг


1. **ОРШИЛ** ... 3
2. **ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА** ... 4
3. **ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ ГАЗРЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ** ... 9
4. **УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ ... 14**
5. **5. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАХ ТАЙЛАН ... 14**
6. **ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН** ... 15
   - 4.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах,арилгах ... 15
   - 4.2 Хөрсөн бүрхэвч түүнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах ... 15
   - 4.3 Ургамлан нөмрөг түүнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах ... 15
   - 4.4 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах ... 15
   - 4.5 Газрын гадарга хэвлий түүнд үзүүлэх сөрөг нөлөөлөл. ... 15
   - 4.6 Шимт хөрсний хуулалт, хадгалалт ... 15
7. **СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН ... 24**
8. **НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТАЙЛАН ... 25**
9. **ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН ... 30**
10. **НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН ... 34**
11. **ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН ... 34**
12. **ОСОЛ ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТАЙЛАН ... 34**
13. **ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТАЙЛАН ... 37**
14. **ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЙЛАН ... 40**
15. **ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ... 42**
16. **ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР ... 43**
17. **ДҮГНЭЛТ ... 44**

**Хүснэгтийн жагсаалт**

***Хүснэгт.1 Уулын ажлын товч танилцуулга***
***Хүснэгт MV-008866 тоот тусгай зөвшөөрлийн булангийн цэгийн солбицол***
***Хүснэгт 3. Агаарын дундаж температур***
***Хүснэгт.4 Бүрэгхангай сумын салхины үзүүлэлт***
***Хүснэгт 5. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан***
***Хүснэгт .6 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний тайлан***
***Хүснэгт.7 Нөхөн сэргээлтийн тайлан***
***Хүснэгт.8 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний тайлан***
***Хүснэгт 9.Осол эрсдэлийн менежментийн тайлан***
***Хүснэгт.10 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт***
***Хүснэгт 11. Удирдлага зохион байгуулалтын тайлан***
***Хүснэгт-13 БОМТ-г хэрэгжилтийг тайлагнах хуваарь***

# 1. ОРШИЛ

“Хос Хас” ХХК-ийн Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт орших Өгөөмөрийн алтны шороон ордыг эзэмшин ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тус ордод MV- 008866, MV-001329, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайнууд хамрагддаг болно.

2025 оны УАТ.нд тусгагдсны дагуу нийт 8655.75 мян.м3 хөрс хуулж дунджаар 680мг.м3 агуулга бүхий 321.97мян.м3 элс олборлох төлөвлөлтийн дагуу ажилласан.

- ***Төслийн нэр***: “Өгөөмөр-IV” нэртэй алтны шороон ордыг ашиглах төслийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээ
- ***Гүйцэтгэгч***: БОННҮ-г “Монслов ”ХХК

## 2. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

**Төслийн байршил**

Өгөөмөрийн алтны шороон орд нь Улаанбаатар хотоос 297 км-т, Дархан хотоос 185 км-т, Эрдэнэт хотоос 180 км-т, Булган аймгийн төвөөс 130 км-т, Бүрэгхангай сумын төвөөс 77 км-т, Хайлаастын алтны уурхайгаас 48 км-т тус тус оршино.

Монгол улсын М1:100’000 масштабтай байр зүйн зургийн М-48-125, М-48-126 дугаартай хавтгайнуудын заагт байрлана. Уг орд байрлаж буй нийт талбайн булангийн цэгүүдийн газар зүйн солбицлыг дараах хүснэгтүүдэд харууллаа.

**Хүснэгт1. Уулын ажлын товч танилцуулга**

| | |
|---|---|
| **1.1 Төслийн нэр** | **“Өгөөмөр”** алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл |
| **1.2 Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага:**<br><br>***БОННҮ хийсэн ААН-ийн нэр*** | **“Хос Хас ” ХХК**<br>Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар:9011064046<br><br>Регистрийн дугаар: **2100231**<br>Бүртгүүлсэн огноо: 2006.12.26<br>Хаяг: УБ хот, БГДүүрэг, 29-р хороо, Эрчим хүчний гудамж 32-р барилга<br>Утас: 99239111,99312173<br>Тус төслийн ТЭЗҮ нэмэлтээр “Баян Овоот Майнинг” ХХК /2025он/<br><br>БОННҮ-г “Монслов ”ХХК хийж гүйцэтгэсэн. /2025 он/ |

***Хүснэгт № 2. MV-008866 тоот тусгай зөвшөөрлийн булангийн цэгийн солбицол***

| № | Уртраг | Өргөрөг | № | Уртраг | Өргөрөг |
|---|---|---|---|---|---|
| 1 | 104° 31' 14.48" | 48° 25' 9.47" | 29 | 104° 28' 37.95" | 48° 23' 6.81" |
| 2 | 104° 31' 24.2" | 48° 25' 9.52" | 30 | 104° 28' 30.95" | 48° 23' 6.81" |
| 3 | 104° 31' 23.94" | 48° 25' 38.64" | 31 | 104° 28' 30.95" | 48° 22' 51.82" |
| 4 | 104° 31' 38.53" | 48° 25' 38.7" | 32 | 104° 28' 57.95" | 48° 22' 51.82" |
| 5 | 104° 31' 38.4" | 48° 25' 51.65" | 33 | 104° 28' 57.95" | 48° 23' 15.31" |
| 6 | 104° 31' 14.03" | 48° 25' 51.7" | 34 | 104° 29' 24.45" | 48° 23' 15.31" |
| 7 | 104° 31' 14.03" | 48° 25' 34.82" | 35 | 104° 29' 24.45" | 48° 23' 8.82" |
| 8 | 104° 31' 6.02" | 48° 25' 34.84" | 36 | 104° 29' 35.95" | 48° 23' 8.82" |
| 9 | 104° 31' 6.02" | 48° 25' 25.83" | 37 | 104° 29' 35.95" | 48° 23' 51.8" |
| 10 | 104° 30' 37.03" | 48° 25' 25.84" | 38 | 104° 30' 1.02" | 48° 23' 51.83" |
| 11 | 104° 30' 37.03" | 48° 25' 15.83" | 39 | 104° 30' 1.02" | 48° 24' 11.84" |
| 12 | 104° 30' 1.02" | 48° 25' 15.83" | 40 | 104° 29' 51.95" | 48° 24' 11.81" |
| 13 | 104° 30' 1.02" | 48° 25' 9.83" | 41 | 104° 29' 51.95" | 48° 24' 3.8" |
| 14 | 104° 29' 43.95" | 48° 25' 9.8" | 42 | 104° 29' 27.95" | 48° 24' 3.8" |
| 15 | 104° 29' 43.95" | 48° 24' 58.8" | 43 | 104° 29' 27.95" | 48° 24' 21.81" |
| 16 | 104° 29' 32.95" | 48° 24' 58.8" | 44 | 104° 29' 33.95" | 48° 24' 21.81" |
| 17 | 104° 29' 32.95" | 48° 24' 51.8" | 45 | 104° 29' 33.95" | 48° 24' 29.8" |
| 18 | 104° 29' 23.95" | 48° 24' 51.8" | 46 | 104° 29' 42.95" | 48° 24' 29.8" |
| 19 | 104° 29' 23.95" | 48° 24' 44.81" | 47 | 104° 29' 42.95" | 48° 24' 41.8" |
| 20 | 104° 29' 16.95" | 48° 24' 44.81" | 48 | 104° 30' 1.02" | 48° 24' 41.83" |
| 21 | 104° 29' 16.95" | 48° 24' 36.8" | 49 | 104° 30' 1.02" | 48° 24' 16.83" |
| 22 | 104° 29' 8.95" | 48° 24' 36.8" | 50 | 104° 30' 41.01" | 48° 24' 16.83" |
| 23 | 104° 29' 8.95" | 48° 24' 29.8" | 51 | 104° 30' 41.01" | 48° 24' 14.3" |
| 24 | 104° 29' 4.95" | 48° 24' 29.8" | 52 | 104° 30' 55.54" | 48° 24' 14.35" |
| 25 | 104° 29' 4.95" | 48° 24' 24.8" | 53 | 104° 30' 55.43" | 48° 24' 25.68" |
| 26 | 104° 28' 57.95" | 48° 24' 24.8" | 54 | 104° 31' 5.17" | 48° 24' 25.72" |
| 27 | 104° 28' 57.95" | 48° 23' 24.81" | 55 | 104° 31' 5.03" | 48° 24' 40.29" |
| 28 | 104° 28' 37.95" | 48° 23' 24.81" | 56 | 104° 31' 14.75" | 48° 24' 40.33" |




***Зураг -1. Төслийн талбайн байрши***

### *1.2* Ус хангамж:

Өгөөмрийн ордын хэмжээнд гүйцэтгэсэн геологийн болон гидрогеологийн ажлын мэдээллийг боловсруулан ордын геологийн нөхцөлийг тодорхойлж, ил аргаар олборлоход ил уурхайд урсан орох газрын доорх усны шүүрэлтийн хэмжээг 19.74 м3/цаг болохыг тооцов.

Унд ахуйн усны хэрэгцээг өөрийн гүний өрөмдмөл худгаас хангана. Ундарга нь 1л/с ба усны химийн найрлага нь гидрокарбонат кальцийн, эрдэсжилт 0.4 г/л-ээс хэтрэхгүй. Химийн найрлагаараа унд ахуйн хэрэглээний усны MNS 900:2005 стандартыг баримтлан, усыг хэмнэлттэй зарцуулахын тулд усан хангамжийг битүү циклээр буюу усан сан байгуулан ажиллана. Усан сангийн нийт багтаамж 200мян.м3 бөгөөд ууршилт, хөрсөн дэх шингэлтээс үүсэх усны алдагдал нь хөрснөөс нэвчин ирэх усаар нөхөн сэлбэгдэж байна. Усны хэрэглээний эргэлтийн усны хэмжээг 75хувиас бууруулахгүй байх зорилт тавин ажиллана.



*Зураг 2. Худгийн барилга.*

### *1.3.* Цахилгаан хангамж:

Төв аймгийн Заамар сумын нутагт байрлаж буй 2*10000кВА чадалтай 110/3 5/6кВ-ын Баясаглант дэд станцаас Өгөөмарийн алтны уурхайд хагийн ойр 17км-т орших дэд станц нь юм. Иймд уурхайг эрчим хүчний эх шшсвэртэй холбох зорилгоор Баясаглант дэ станцаас Заамар сумын Өгөөмөр тосгоныг холбосон сүлжээнээс 35кВ-ийн өндөр хүчдэлийн шугамыг шинээр татан, улсын эрчим хүчний системд холбогдсон . Уурхайд 44кВт чадалтай 8геeп -80м3 маркийн элс угаах төхөөрөмж 2ш, 25кВт чадалтай шахах Д-280/75 носас-+2, Д-320/90 маркийн ус татах 2 ширхэг носас, 18кВт чадалтай Р1-110РЕ маркийн гүний худгийн носас , уурхайн гэрэлтүүлэг, засварын цех, граш, үйлдвэрийн талбай, уурхайн захиргаа, ажилчидын байр зэрэг цахилгаан хэрэглэгчид нь 0,4кВ-ын цахилгаан эрчим хүчээр хангагдсан болно.

### *1.4.* Хүчин чадал, техник технологи

Алт агуулсан элсийг угаан баяжуулах технологийн үзүүлэлт, тус ордод хийсэн лабораторийн шинжилгээний үр дүн /алтны 57,03% нь -0,63 мм-+0,16 мм/ зэргийг харгалзан эргэлтэт скруббер ба шлюзийн хослол бүхий баяжуулах төхөөрөмжөөр ялган авдаг. Алттай давхаргаас олборлосон элсийг угаах төхөөрөмжинд усан буугаар буудаж хийхэд хүлээн авах торон дээр +100 мм-ийн том чулуунууд ялгаран хаягдаж, -100 мм нь

эргэлтийн шигшүүрт угаагдан +20 мм, -20 мм-ийн хэмжээтэй ангилагдана. -20 мм нь ахин ангилагдаж +5 мм, -5 мм хэмжээтэй ангилагдана. Угаагдаж байгаа элсний +20 мм, +5 мм-ийн хэмжээтэй нь хуурай хаягдалд овоологдон бульдозероор түрэгдэн овоологдох ба -5 мм хүртлэх мөхлөгүүд нь шлюзэд тунан угаагддаг.

Баяжуулж байгаа технологи нь элсний ашигт эрдсийг аль болох өндөр хувиар ялган авах зорилготой бөгөөд үйлдвэрээс гарч байгаа технологийн хаягдал нь байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй байхаар шийдэгдсэн байна.

### *1.5.* Уул технологийн хэсэг

Хос Хас ХХК нь коматцу PC-1250, PC-600-2ш Doosan-500-2ш HD465, Норд , Тонли маркийн автосамосвал, ковш зэрэг техник тоног төхөөрөмжийг ашиглан хийж гүйцэтгэдэг . Комацу ,Doosan экскаваторын тусламжтай ухаж шидэх , шилжүүлэн зөөх болон ТОНЛИ маркийн автосамосвалын хослолоор тээвэртэй ашиглалтын системээр ил аргаар ашигласан ба хөрсний овоолгыг нөхөн дүүргэх ажил гүйцэтэнэ.

## 3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ ГАЗРЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

Төслийн талбай нь Хэнтийн уулархаг мужийн баруун өмнөд хэсэгт Орхон Туулын бэлчирт , Туул голын доод хэсэгт оршино. Туул голын сав газар нь далайн түвшинээс харьцангуй өндөр өргөгдсөн , далай тэнгисийн алслагдсан , эргэн тойрон уулсаар хүрээлэгдсэн тул өдөр шөнийн агаарын темпратурын ялгаа их хүйтэний улирал харьцангуй урт харин зун богино хур тундасны ихэнхи хувь нь дулааны улиралд орох бөгөөд ихэвчлэн агаарын тогтворгүйцилээс үүдэн конвекцийн гаралтай байдаг. Эх газрын эрс тэс уур амьсгалтай , хамгийн хүйтжн сар нь 1-р сард -37°С-40°С , хамгийн дулаан сар нь 7-р сард агаарын темпратур +32°С хүрдэг .

**Хөрс-газарзүйн мужлалын хувьд** Хангай их мужийн Хар хүрэн , хүрэн хөрсний дэд бүсийн Орхон-Шаамарын хөрсний тойрогт тус тус хамрагдаж байна. Тусгай зөвшөөрөлтэй талбайнуудаар Хөнгөн шавранцар доор карбонаттай Хар хүрэн , Сайргархаг, карбонаттай хөнгөн шавранцар Хар хүрэн хөрс, хөнгөн шавранцар хүрэн хөрс зэрэг 3 хэв төрлийн хөрс тархсан байна.

**Ургамал-Газарзүйн мужлалын хувьд** Евроазийн шилмүүст ой, нуга хээрийн их муж чийглэгдүү нхэв шинжийн Дорнрд азийн муж Орхон-Туулын нам уулын тойрогт хамаарагдана. /Монгол улсын үндэсний атлас 2009 он/ . Монгол орны Физик- Газарзүйн мужлалаар Хангайн уулт их муж, Орхон Туулын сав бэсрэг уулсын муж Орхон Ерөө голын тойрогт багтана. Олборлолт явуулахаар төлөвлөж буй тусгай зөвшөөрөлтэй талбай нь нам уулсын уулын хээр, дэнжийн ургамалжилттай. Карбонаттай, хөнгөн шавранцар хүрэн хөрстэй дэнжийн хээр нь тусгай зөвшөөрөлтэй талбайн зүүн хойд талаар голын дэнж хэсэгт орших ба үетэн-алаг өвст бүлгэмдэл тархана.

**Ус зүй:**Туулын сав газар орших бөгөөд тус сав газар нь Монгол орны амьтаны аймгийн газарзүйн мужлалаар /Банников 1954/ Монгол дагуурын хээрийн тойрог , Хангайн тойрог хооронд оршдог тул амьтаны аймгийн бүрэлдхүүний хувьд нилээд өвөрмөү бөгөөд баялаг байжээ. Түүнчлэн энэ бүс нутаг нь байгалийн хувьд олон янзын амьдрах орчныг өөртөө агуулсан учир ихээхэн онцлогтой. Жишээлбэл энд хээрийн үндсэн амьтад, голын сав газрыг түшин амьдардаг амьтад зонхилон тархсан байна. Энэ бүс нутагт Монгол оронд хаягүй өргөн тархацтай, тоо толгойн хувьд ч элбэг тааралдах

амьтдын төлөөлөгчид ч байдаг байжээ.

## 1.1. Уур амьсгал

Монгол орны уур амьсгал тус орны газарзүйн байршил онцлог, газрын гадаргын тогтоц, далайн төвшнөөс дээшхи өндөршлөөс шалтгаална. Өндөр уул, тэгш тал алаглан гадаргын байдал янз бүр байдаг явдал тухайн нутгийн уур амьсгалын өөрчлөлт, цаг агаарын байдалд ихээхэн нөлөө үзүүлдэг юм. Хуурайдуу сэрүүн

зунтай, хүйтэн өвөлтэй.1-р сарын дундаж -17$^0$С,7-р сарын дундаж 15.5$^0$С, жилийн дундаж салхины хурд 5-10м/сек, жилийн хур тундасны нийлбэр 300- 400мм.




***Хүснэгт 3. Агаарын дундаж температур***

## 1.2. Хөрсний температур

2017 оны байдлаар хөрсний гадаргын температурын жилийн дундаж 0.9$^0$ С хүйтнээс 4.7$^0$ С дулаан ОЖД-тай харьцуулахад 0.5-1.7$^0$ С хүйтэн, бусад нутгаар 0.5-2.1$^0$С дулаан байсан байна .Хөрсний гадаргын үнэмлэхүй их температур 8-р сард 65.00С ба бусад нутгаар 51.0- 61.70С хүрч халсан байна. Хөрсний гадаргын үнэмлэхүй бага температур 11-р сард тус суманд 49.80С, бусад нутгаар 35- 44.00С хүрч хүйтэрсэн байна.

Хөрсний гадарга дээр өдөртөө 6-7 дугаар сард нийт нутгаар 60-68 градус, 8 дугаар сард ихэнх нутгаар 50-59 градус хүрч халсан байна.

1 дүгээр сард агаарын дундаж температур -17.0$^0$С, хамгийн их температур - 2.3$^0$С, хамгийн бага температур -29.4$^0$С байдаг бол 7 дугаар сард дундаж температур 19.4$^0$С, хамгийн их температур 32$^0$С, хамгийн бага температур 7.0$^0$С байдаг байна.
Бүрэгхангай сумын агаарын температурын сар бүрийн утгыг доорх хүснэгтэд үзүүлэв.

*Хүснэгт-3 Бүрэгхангай сумын темпратурын үзүүлэлт*

| Сар/үзүүлэлт | I | II | III | IV | V | VI | VII | VIII | IX | X | XI | XII |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Сарын дундаж температур | -21.9 | -17.9 | -4.7 | 4 | 11.5 | 17.7 | 16.4 | 16.6 | 15.9 | 7.4 | -8.7 | -14.8 |
| Хамгийн бага температур | -2.3 | 0.8 | 15.4 | 23.0 | 29.2 | 30.3 | 32.0 | 30.6 | 25.2 | 19.8 | 10.7 | 0.13 |
| Хамгийн их температур | -29.4 | -26.0 | -20.9 | -11.9 | -5.0 | 2.6 | 6.9 | 3.9 | -4.14 | -11.8 | -24.6 | -27.2 |

### 1.3. Хур тунадас

Хур тунадас бол тус орны нутаг дэвсгэрийн уур амьсгалын нөхцөлийг илэрхийлэгч чухал хүчин зүйлийн нэг юм. Тунадасны хуваарилалт газар нутгийн өндөр, ялангуяа чийг авч яваа агаарын урсгалын замд тохиолддог уулс яаж байрласнаас ихээхэн шалтгаалдаг. Бүрэнхангай сумын хувьд хур тунадасны 2017 оны жилийн хүйтний улирлын хур тунадасны дундаж хэмжээ 0.3-1.6 мм, дулааны улирлын хур тунадасны дулааны хэмжээ 2.5-5.3 мм байна. Нийт унах хур тунадасны ихэнх дулааны улиралд унадаг. Үүнээс харахад хур тунадас олон жилийн дундажаас бага байна.

### 1.4. Салхины горим

Агаарын даралт газрын гадарга дээр жигд бус хуваарилагдсанаас болж салхи буюу агаарын урсгал үүсч тэр нь дулаан хүйтэн, чийг, цас, бороо гэх мэт олон үзэгдлийг нэг газраас нөгөөд зөөж байдгийн хувьд агаарын даралт уур амьсгалын чухал элемент болдог. Салхины хамгийн их хурд 6-8 м/с, салхигүй өдрийн тоо 26, 15 м/с ба түүнээс

хүчтэй салхитай өдрийн тоо жилд 30, цасан шуургатай өдрийн тоо жилд 10- аас дээш, явган шуургатай өдрийн тоо жилд 10, шороон шуургатай өдрийн тоо жилд 30 байдаг байна. Салхины хамгийн их хурд 25 м/с хүрч байсан.

Салхины жилийн дундаж хурд 1.4-4.0 м/с, хамгийн их хурд 15-28 м/с буюу аюултай үзэгдлийн хэмжээнд хүрсэн байна. 2-9, 11-12 дугаар сарууддад салхины их хурд Булган, Хутаг, Сэлэнгэ, Могод, Гурванбулаг, Орхон, Хишиг-Өндөр, Дашинчилэн, Бүрэгхангай сумдын нутгаар 20-28м/с бусад нутгаар 12-17м/с хүрч салхилсан байна. 4- р сард Бүрэгхангай суманд салхины хурд 28 м/с хүрчээ.

***Хүснэгт.4 Бүрэгхангай сумын салхины үзүүлэлт***

| Сар / Үзүүлэлт | I | II | III | IV | V | VI | VII | VIII | IX | X | XI | XII |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Дундаж хурд, м/с | 2.2 | 2.2 | 3.6 | 5,0 | 4.9 | 4.1 | 3.0 | 3.0 | 3.2 | 3.3 | 3.0 | 2.1 |
| Хамгийн их хурд, м/с | 15 | 18 | 22 | 20 | 17 | 22 | 20 | 17 | 22 | 19 | 14 | 18 |
| Хамгийн бага хурд, м/с | 1.2 | 1.9 | 2.4 | 3.1 | 3.1 | 3.1 | 2.0 | 1.9 | 2.3 | 2.6 | 1.5 | 1.4 |

## 1.5. Ус зүй

Ус зүйн сүлжээ их бөгөөд умард мөсөн далайн ай савд багтна. Гол сүлжээний нягтшил 0.10-0.15 км/км$^2$ байдаг. Гол мөрний нийлбэр урсац, газар доорх урсац, гадаргын урсац зэрэг нь 25мм-ээс дээш юм. Газар нутгийн чийгшил 200-250 мм, ууршилт200-250мм жилийн дулаан үеийн ууршилт 600-800 мм гол мөрний усны булингар 100 г/м$^3$ -аас дээш. Хатуу урсац жилд 3 м/км$^2$ дээш. Шар усны үерийн хамгийн их урсац хойд болон баруун нутгаар 10мм-ээс доош, зүүн болон өмнөд нутгийн багахан хэсгээр 250мм орчим. Бороосны үерийн хамгийн их урсацын модуль 0.2-ээс дээш байдаг.

## 1.6. Хөрс

Бүрэгхэнгайн сумын нутагт орших ба төслийн талбайн хамрах бөгөөд Хөрс-Газарзүйн мужлалтаар хөрс био-уур амьсгалын өргөргийн бүсчлэл бүхий Хангайн их мужийн*, Хархүрэн, хүрэн хөрсний дэд бүст, Орхон -Шаамрын 1-р тойрогт* багтана. Тус нутагт ихэвчлэн уулын хар шороон хөрс, уулын хүрэн шороон хөрс зонхилж байдаг. Тухайн талбайд ерөнхийд уулын хар шороон хөрс, уулын хүрэн шороон хөрс тогтворжсон.

Монгол орны ботаник- газар зүйн мужлалаар Евразийн шилмүүст ой, нуга хээрийн их мужийн Дорнод азийн дэд мужийн Орхон-Туул нам уулсын хээрийн газарзүйн тойрогт хамааргддаг. Тус бүс нутаг ихэнх нутгийг Уулын хээрийн тойргийн ургамалжилттай. Байгалийн бүс бүслүүрийн хувьд (А.А.Юнатовынхаар) Дундаж өндөр ба нам уулсын хээрийн бүсэд багтана. Тус бүс нутагт үндсэндээ чулуулаг алаг өвс- ботуульт хэв шинжүүдийн ургамжилт ихэвчлэн зонхилдог. Ургамал газарзүйн мужлалаар Хангайн уулын ойт хээрийн провинц, Сэлэнгийн уулын ойт хээрийн тойргийн Бүрэгхангайн районд хамрагдана. Уулс нь налуу мөлгөр энгэртэй, хавтгайдуу оройтой гол төлөв арааараа шинэс хусан ойтой.

## 1.7. Амьтны аймаг

Ойн тархмал мэрэгчийн нэг хэрэм гол тэжээлээ дагаж хушин ойд хамгийн элбэг байна. Ойн зах унанги дархи, асга чулуутай хэсэгт жирх элбэг. Туурайтнаас бор гөрөөс, буга, зэрлэг гахай бүх ойт нугийн энгэрээр тархмал гэж болно. Аймгийн хамгийн хойд хэсэгт тайгын өндөр уулсын ар хажуугаар хүдэр нутаглана. Хантай, Бүрэн, Бүтээлийн нуруугаар хандгай, хүрэн баавгай, булга, нохой зээх нутаглана. Агнуураас шалтгаалан булга нэг үе их ховордсон ч өсч байна.Уулын өмнөд өвөр хажуу бэл голын хөндийн ой модгүй задгай газарт идээшсэн олон зүйл амьтан бий. Энд 16-17 зүйл мэрэгч тохилдохоос тарвага, урт сүүлт зурам, сибирийн алга даага, үлийн цагаан оготно, үлийн бор оготно бусдаас элбэг байна. *Шавьж идэштнээс*

дагуурын зараа, хонин малтаахай хоёр голын татам дэнж бэл хөндийгөөр тохилддог. Жижиг мэрэгч шувуу элбэг байгаа нь энд хярс, өмхий хүрэн зэрэг махан идэштэн олон байх нөгцөл болжээ. Хад чулуутай уулсаар мануул ховор биш үзэгдэнэ.

## 4. УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

Тухайн ордын уул геологийн нөхцөлд тохирох технологийг сонгон хэрэгжүүлж, зохион байгуулалтын хувьд бэрхшээлгүй үйлдвэрлэл явуулан, эдийн засгийн үр өгөөжийг хангахад ашигт малтмалын ордыг ашиглах аргын үндсэн зорилго чиглэдэг. Өгөөмөр-IV алтны шороон ордын хувьд дундаж гүн 32.0м туул голын дэнжийн хэсгийг хамран оршино. Манай компани нь 2018-2023 оны хооронд тус талбайд геологи хайгуулын ажил гүйцэтгэж нөөцийн нэмэлт тодотгол тайлан ТЭЗҮ-г хэлэлцүүлэн БОННҮ-тайлангийн тодотгол боловсруулж хэрэгжүүлсэн байна.

## 5. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАХ ТАЙЛАН

2025 оны байгаль орчныг менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа төслийн БОНБНҮ тайлан болон тус тайланд тусгасан ОХШХ-г үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ авах юм. Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгахыг эрмэлзсэн бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж ажилласан.

2025 оны Байгаль орчны менежментийн биелэлтийн тайланг хэрэгжүүлэхэд 381.4 сая төгрөгийг зарцуулсан.

***Хүснэгт 5. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн зардал***

| № | Бүрэлдэхүүн хэсгүүд | Төсөв сая.төг |
|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 3.0 |
| 2 | Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө | - |
| 3 | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө | 62.0 |
| 4 | Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | 0.7 |
| 5 | Дүйцүүлэн хамгаалах хөтөлбөр | 310.9 |
| 6 | Олон нийт тайлагнах хөтөлбөр | 1.2 |
| 7 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 3.6 |
| | Нийт | 381.4 |

# 5. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүдийг тодорхойлоход уурхайн явцад газрын гадарга, газрын хэвлий, хөрс, ургамал, агаар орчин бохирдох, хүний эрүүл мэнд зэрэгт сөргөөр нөлөөлөх нь тогтоогдсон. Иймд төслийг хэрэгжүүлэх үед үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг авч ажилласан.

## 5.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Төслийн агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахын тулд дараах арга хэмжээг авна. Үүнд:

- Уурхайн тээвэрлэлтийн улмаас тоосжилт үүсэх-Тоос баригч байгальд ээлтэй, сөрөг нөлөөлөл бага орчин үеийн технологид нийцсэн томоохон уул, уурхайнуудад ашиглаж байгаа сайн туршлага судалж танилцуулсан.
- Төслийн үйл ажиллагаанд ашиглах машин механизмуудын утаат яндангаас ялгарах хорт хийн агууламжийг бууруулах зорилгоор утааны яндaнд тухай бүрд нь техникийн засвар үйлчилгээг хийсэн.
- Хөрс хуулалт хийгдэх явцад агаарт дэгдэх тоосны хэмжээг бууруулахын тулд дотоод болон орон нутгийн технологийн зам талбайг тухай бүрд нь усалж, чийгтэй байлгах арга хэмжээ авсан.
- Уурхайн үйл ажиллагаанаас агаарт тархах тоосны хэмжээг багасгах, замын тоосжилтыг багасгах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд мод тарих ажлыг зохион байгуулсан.

## 5.2 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

- Төслийн явцад хөрсийг ахуйн ба үйлдвэрлэлийн хог хаягдал болон нефтийн бүтээгдэхүүнээр бохирдохоос урьдчилан сэргийлж ажилласан.
- Уурхайгаас гарах шороог төлөвлөлтийн дагуу овоолгын талбайд зөв байрлуулан асгаж, дагтаршуулах, хур тунадас, салхины нөлөөгөөр үүсэх хагарал, хотойлт зэргийн шалтгааныг судалж түүнээс урьдчилан сэргийлж ажилласан.
- Тээвэрлэлтийн явцад кемп лүү орох, гарах маршрутыг нарийвчлан тогтоох, олон салаа зам гаргахгүй байх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажилласан.
- “Завсар механикийн” техникийн хаягдал тос масло хураах нэгтсэн цэгт тогтмол төвлөрүүлэх, дахин боловсруулах үйлдвэртэй гэрээ хийж хамтран ажиллаж байна.
- Тосолгооны поошигнуудыг шаардлага хангасан түр цэгт хурааж, гэрээний дагуу хамтран ажиллаж байгаа газруудад явуулах ажлыг тухай бүрд нь хийж байна.

## 5.3 Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Газрын доорх ус буюу ундны усны нөөцийг бохирдуулагч эх үүсвэр нь хөрсний бохирдол юм. Хөрсөн дээр асгарсан, гоожсон шатах, тослох материал түүний үе давхаргуудад шүүрэн нэвчиж газрын доорх усыг бохирдуулна.

- Унд ахуйн хэрэгцээний усны чанар нь стандарт, норм, нормативд нийцэхийг шалгаж жилд 2 удаа шинжилгээнд хамруулсан.
- Хөрсийг шатах, тослох материалаар бохирдохоос урьдчилан сэргийлж ажилласан.

## 5.4 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Уурхайн үйл ажиллагаа эхэлсэнээс хойш ургамлын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах замаар дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Төслийн талбайн эргэн тойрон дох ургамал бүрхэвчийг хамгаалах үүднээс олон салаа зам гаргахгүй байх үүднээс
- Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх үүднээс хогийн ангилан ялгалтын нэгдсэн цэг байгуулсан.
- Төлөвлөлтийн дагуу 23.000ш мод тарьсан.
- Нөхөн сэргээлтийн бэлтгэл үе шатыг хангах үүднээс үржүүлгийн талбай бий болгох үүднээс 6х27.той хүлэмжийг ашиглалтанд оруулж, хайлаас үрээр тарилт хийсэн.

## 5.5 Шимт хөрс хуулалт хадгалалт

Төслийн талбай нь Хэнтийн уулархаг мужийн баруун өмнөд хэсгийн бүсэд хамаарах бөгөөд уг бүслүүрт хөнгөн шаврански доор карбонаттай хар хүрэн, сайрхаг карбонаттай хөнгөн шаврански, хар хүрэн хөрс,

хөнгөн шавранцар хүрэн хөрс зохилон тархдаг бөгөөд шимт хөрсийг тухай бүс бүслүүрийн онцлогоос хамааруулан 20 см-ээр MNS 5916:2023 стандарт шаардлагын дагуу хуулж хадгалсан. Үүнд дараах арга хэмжээг тухай бүрд нь авч хэрэгжүүлсэн.

- Үржил шимт хөрс хуулалтыг стандартын дагуу хийх технологийг уулын мастер, машин механизмын оператор нарт эзэмшүүлсэн.
- Шимт хөрсний овоолгыг газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008 стандартын дагуу хуулж, хадгалсан.
- Шимт хөрсний овоолгыг салхинд хийсэх, усанд автах, хужиртах,бохирдохоос хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүрд нь авч хэрэгжүүлсэн.

# 6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН

Энэхүү сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө нь “Хос Хас ХХК “Өгөөмөр ” шороон ордыг ашиглах үед байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаварыг тогтмол хянах,бууруулах арга хэмжээний төлөвлөгөө бөгөөд дараах хүснэгтэд тусгагдсан арга хэмжээг тогтоосон хугацаанд хэрэгжүүлэн ажиллахаас гадна тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд нэг бүрчлэн тусгаж, биелэлтийн тайланд хийж хэрэгжүүлсэн ажлуудыг зарцуулсан төсөв мөнгөн дүнг доорх хүснэгтээр үзүүллээ.

## 6.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЙЛАН:

*Хүснэгт .6 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний тайлан*

| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ | Байгаль орчныг хамгаалахад авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | Хамрах хүрээ | Нэгжийн өртөг сая/т | Хэрэгжүүлэгч | Зураг |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **АГААР МАНДАЛД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ , БУУРУУЛАХ, БАГАСГАХ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ** | | | | | | |
| 1 | Тоосжилт, агаарын бохирдолын эх үүсвэрүүд | 1.1 Дотоод тээвэрлэлтээс үүсэх тоосжилтийг дарах зорилгоор усалгаа хийх /Зуны улиралд/ | Уурхайн дотоод болон орон нутгийн зам талбайн усалгааг тогтмол хийж байна./зуны улиралд өдөрт 3-4удаа/. | Төслийн талбай болон орон нутгийн зам. | ҮАЗ | Ажиллах хугацаанд |  |
| | Хөрсний чийг бага салхи ихтэй үед агаар дахь тоосны хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрэх | 1.2 Төслийн үйл ажиллагаанп ашиглах, машин техникүүдийг улсын үзлэгт тухай бүрд нь хамруулах /Агаарын бохирдолын төлбөр төлөх/ | Төслийн үйл ажиллагаанд нийт-машин техник ажиллаж байна. Улсын үзлэгт хамрагдсан. | Уурхай машин техник | ҮАЗ | Ажиллах хугацаанд | |
| | | 1.3 Тоосжилт бууруулах, тоос барих технологи, сайн туршлагийг судлах | Замын тоосжилт дарах-Тоос дарагч Лигносульфонатийн талаар судалгаа хийж уурхайн удирдлагуудад танилцуулсан. | Төслийн талбайд | 800.0 | Ажилла х хугацаанд |  **Давуу тал** 1. Байгальд ээлтэй био задардаг 2. Усны хэрэглээг бууруулдаг: Ус хадгалах чадвар нь өндөр тул бага давтамжтайгаар шүршиж болно. 3. Чийг хадгалах чадвартай 4. Зам уурхайн нөхцөлд 1-2 долоо хоног үр дүнтэй байдаг. 5. Мал амьтанд хоргүй. **Хэрэглэх заавар**-Усалгааны машин эсвэл шүршигч ашиглан 1м2 талбайд 0.5-1.5 литр уусмал уусгах байдлаар. **20тн усанд**-50-100литр Лигносульфонат |
| | | 1.4 Технологийн зам дагуух тэмдэг тэмдэглэгээг засаж сайжруулах, нэмэлт тэмдэг байршуулах. | Заах тэмдэг-13ш, анхааруулах тэмдэг-19ш, хориглох тэмдэг-4ш байршуулсан.Нийт-61 тэмдэг байршуулсан. Тухай бүрд нь замын хусалт хийж байна. | Уурхайн дотоод,гадаад зам талбай | ХАБ -ын зард алд | Төсөл хэрэгжих хугацаанд | |
| | | 1.5 Тээвэрэлт хийх шороон замд тээврийн жолооч нарт хурдны хязгаарлалт тавих | Хурдны хязгаарлалтын 25ш тогтмол хяналт тавьж ажиллаж байна. | Төслийн талбай | | Ажиллах хугацаанд | |
| *Дүн* | | | | | *Нийт-800,0* | | |
| | **2. ХӨРС ГАЗРЫН ГАДАРГАД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ** | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Хөрс хуулалт хийх, зам талбай гаргах, төслийн талбайн үйл ажиллагааны үед тухайн орчны өнгөн хөрс элэгдэх, үржил шимт чанар нь алдагдах | Хөрс хуулалт хийх, баяжуулах үйл ажиллагааны үед тухайн орчны өнгөн хөрс элэгдэх, үржил шимт чанар алдагдах | Уулын ажлын төлөвлөгөөгөөр карьерын тэлэлт хийгдэх бүрд хөрсний үржил шимт чанараас хамааран 30- 50см орчим зузаан хуулж шимт хөрсний овоолгийн талбай үүсгэсэн. | Төслийн талбай уулын хэсэг. | | Ажиллах хугацаанд |  |
| | | Бензин тос, дизель шатах тослох, материал зэргийн асгаралт ахуйн хог хаягдалаас хөрсний бохирдол үүсэх | Техникийн хаягдал тосыг дахин боловсруулах “Төгс инжиниринг” ХХК, ‘Алтай оршихуй” ХХК-д нийт 4 удаагийн давтамжтай 66.5тн тос нийлүүлсэн. | Төслийн талбай ЗМХ. | ҮАЗ | Төслийн ү.а-ний хүрээнд |  |
| | Хөрс, газрын гадарга олон машин техникийн нөлөөгөөр талхлагдах | Хүнд машин техникийн хөдөлгөөнөөс олон салаа зам гарах, хөрсний шороо суларч элэгдэл эвдрэлт өртөх | Хөрсний бохирдол-сургалт уулын хэсгийн нийт-56 операторт орсон. Замын нэгтгэл хийж-тэмдэгжүүлэлт байршуулсан. | Уулын хэсэг, ЗМХ, операторууд | 500.0 | |  |
| | | | | | | | Дүн 500.0 |
| **УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРИЛГАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| 3 | Усны сан бүхий газар, түүний онцгой хамгаалалтын бүс, унд ахуйн худгийн эрүүл ахуйн бүс хог хаягдлаар бохирдох, уурхайн үйл ажиллагаанд өртөх | Жил бүр ус ашиглах дүгнэлтийг холбогдох төрийн байгууллагаар гаргуулж ажиллах. | Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг “УСНЫ ГАЗАР”-р 2025 онд Өгөөмөр шороон ордны ус ашиглах дүгнэлтийг гаргуулсан. | Уурхай, кемпийн хэмжээнд | | Уулын хэсэг |  |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Гадаргын болон гүний усан орчинд урсацын горим алдагдаж болзошгүй | Усан хангамжийн худгууд дээр усны чанарын шинжилгээг хийх, хяналт тавьж ажиллах. | Булган аймгийн УЦУОШТ-ийн лабораторид жилд 2 удаа тогтмол хийлгэдэг. /6,9 саруудад/ | Уурхай, кемпийн хэмжээнд | | БОМ |  |
| | | | | | | | Дүн 900 |
| | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **УРГАМЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ, АРИЛГАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| 4 | Газар шорооны ажил болон машин техникийн хөдөлгөөнөөр орчны ургамлан нөмрөгт нөлөөлөл үзүүлнэ. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх | Өмнө жилүүдэд суулгасан модны суулгацын усалгаа, арчилгаар гүйцэтгэх. /Усалгааны хуваарь гаргах/ 4.3 Хайлаас үр-2кг Бургас мөчрөөр-2000ш бэлтгэж стандартын дагуу хадгалах. | Ургамлан хашлагаар таригдсан хайлаасны шуудууг өргөсгөсөн. Усалгааны хуваарь боловсруулж, гаргасан. Хүлэмжинд үрээр-250ш хайлаас тарьсан. Бортого, ил талбайд. | Тарилт хийсэн газруудад | ҮАЗ-д тусгагдсан | Уурхайн байгаль орчин |  |
| | | 4.2 Уурхайн дотоод, гадаад тээвэрлэлтийн маршрутыг зөв гаргах. /Ургамлан нөмрөгт сөрөг нөлөөлөл үзүүлэх талбайг хамгийн бага хэмжээнд төлөвлөх/. | Тээвэрлэлтийн замын маршрутыг дахин төлөвлөж, шаардлаггүй замуудыг хаасан. | Төслийн талбайн хэмжээнд | | Байгаль орчин, Уулын хэсэг. |  |
| | | | | | | | Дүн - |

| **5. АМЬТАНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ** | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Төслийн үйл ажиллагаанд том машин техникийн нөлөөгөр зэрлэг ан амьтадын тоо толгой буурах, үргэж дайжих сөрөг нөлөөтэй | 5.1 Төслийн талбайд боломжтой газруудад хаягдал мод ашиглан шувууны үүр хийж байршуулах. | Кемпийн талбайн эргэн тойронд нийт-15ш шувууний үүр хийж байршуулсан. | Кемпийн хэмжээнд | | БОМ, Кемп менежер |  |
| | | 5.2 Төслийн явцад тээврийн жолоочдыг зэрлэг ан амьтныг цочоож үргээхгүй байх, хууль бусаар ан ав хийлгэхгүй байх талаар сургалт орж, хяналт тавих | Төслийн явцад зэрлэг ан амьтныг цочоож үргээх, агнахгүй байх талаар ерөнхий сургалтанд нэмэлтээр орсон. | Уурхайн ажилчид | | БОМ, Хэсэг нэгжийн ахлахууд |  |
| | | **Нийт** | ***15 ажил хэрэгжүүлсэн.*** | | 3.000 | | |

**<u>Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах</u>**

Уурхайн дотоод,орон нутгийн зам талбайн усалгаа.





Карьерын доторх гадна талбайн зам усалгаа.

**АГААР ОРЧИНГ ХАМГААЛАХ**

Замын тоосжилт дарах-Тоос дарагч **Лигносульфонат** нь модны целлюлозын үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн бөгөөд тоосонцрыг наалдуулах жинг нэмэгдүүлэх замаар агаарт дэгдэхээс сэргийлдэг. Монголд-Эрдэнэт үйлдвэр, Тавантолгой зэрэг уурхайнуудад ашиглаж байна.

**Хоруу чанар**: Шороон замын тоосжилтыг лигносульфонатын органик барьцалдуулагч бодисыг ашиглан байгаль орчинд хоргүй аюулгүйгээс гадна хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх ургамлын ургах чадварыг сайжруулах бордоо болох зэрэг олон талын ач холбогдолтой бодис юм.



**Давуу тал**

1. Байгальд ээлтэй био задардаг
2. Усны хэрэглээг бууруулдаг: Ус хадгалах чадвар нь өндөр тул бага давтамжтайгаар шүршиж болно.
3. Чийг хадгалах чадвартай
4. Зам уурхайн нөхцөлд 1-2 долоо хоног үр дүнтэй байдаг.
5. Мал амьтанд хоргүй.

**Хэрэглэх заавар**-Усалгааны машин эсвэл шүршигч ашиглан 1м2 талбайд 0.5-1.5 литр уусмал уусгах байдлаар.

Замын тоосжилт дарах- Лигносульфонат нь модны целлюлозын үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн бөгөөд тоосонцрыг наалдуулах жинг нэмэгдүүлэх замаар агаарт дэгдэхээс сэргийлдэг. Монголд-Эрдэнэт үйлдвэр, Тавантолгой зэрэг уурхайнуудад ашиглаж байн





Технологийн зам талбайг тухай бүрд нь хусах ажлыг хийж гүйцэтгэдэг.

**Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах**

Техникийн хаягдал тос дахин боловсруулах үйлдвэрт нийт 3 удаагийн давтамжтай 65 тн хаягдал тосыг “Төгс билэг инженеринг” ХХК-д нийлүүлсэн.


ТЕХНИКИЙН ХАЯГДАЛ ТОС НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Улаанбаатар хот

ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ





| Д/д | Хуанли/сар | | | | | | | | Нийлүүлсэн тос/хэмжээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Сар/өдөр | IV | V | VI | VII | VIII | IX | X | XI | XII | 66.5тн |
| Хэмжээ/тн | 20тн | 15тн | | 20тн | | 11.5тн | | | | |









“АХХ-ыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, бүртгэх тайлагнах журам” Байгаль орчин аялал жуулчлалбн сайдын тушаал А/18




Аюултай хог хаягдал Тос масло хураах цэг бүртгэлийг дугаарын дагуу ангилан ялгалт хийж, байршуулсан байна.

**Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах**

Газрын доорх ус буюу ундны усны нөөцийг бохирдуулагч эх үүсвэр нь хөрсний бохирдол юм. Хөрсөн дээр асгарсан, гоожсон шатах, тослох материал түүний үе давхаргуудад шүүрэн нэвчиж газрын доорх усыг бохирдуулна.

*Ажлын байрны үзлэг хариу арга хэмжээ*

| № | Аюулын зэрэг | Зураг | Авсан арга хэмжээ | Хариуцах эзэн | Гүйцэтгэлийн зураг |
|---|---|---|---|---|---|
| 1 | A |  | Хөрсний бохирдол үүсгэсэн талбайг цэвэрлэсэн. | ЗМХ Ерөнхий механик П. Бүрэнтөгс Механик инженер Ц. Бат-Эрдэнэ |  |
| 2 | A |  | HD-465#02-ын хөдөлгүүр суурилуулах ажил хийгдэж дууссан. Орчны бохирдолыг цэвэрлэсэн. | ЗМХ Ерөнхий механик П. Бүрэнтөгс Механик инженер Ц. Бат-Эрдэнэ |  |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | D |  | Усан орчин хамгаалах. Зам талбайг тэгшлэх, засаж сайжруулах | Уулын инженер Ц. Энхтайван | 3 хоног |

Үл тохирлыг холбогдох хэсэг нэгж тус бүрээр мэйлээр явуулдаг. Заасан хугацаанд үл тохирлыг арилгаж, тайланг илгээдэг.

- БОМТ-ийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу жилд 1-2 удаа тогтмол ОХШ-хийлгэх-Тайлант онд Булган аймгийн “**УС ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ”-өөр** хийлгэсэн.

**Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах**

Төслийн талбайн эргэн тойрон дох ургамал бүрхэвчийг хамгаалах үүднээс олон салаа зам гаргахгүй байх үүднээс уурхайн дотоод зам, орон нутгийн замуудад нийтдээ 67 ширхэг тэмдэг тэмдэглэгээг шинээр хийж, засаж сайжруулж, шаардлагатай газруудад байршуулсан байна.





Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх үүднээс хогийн ангилан ялгалтын нэгдсэн цэг байгуулсан.







**Төлөвлөлтийн дагуу** 23.000ш мод тарьсан.

Тарилтыг хугацаанд нь зөв тарьж ургуулахаас гадна арчилгаа, усалгаа цаг тухай бүрд, хийж өгөх нь илүү үр дүнтэй ургалтын эрчимд сайнаар нөлөөлдөг






Био ундарга ХХК-аас гаргадаг Биогум модны бордоог мөчрөөр тарилт хийхэд бэлтгэл ажлыг ханган үүнийг ажлын уусмал бэлтгэн ашигласан

**<u>Биогум бордооны давуу тал</u>**

- Ургамлын ургалт, үндэсний системд чухал ач холбогдолтой.
- Чийг хадгалах чадварыг нэмэгдүүлнэ.
- Хөрсний бүтэц агааржилтыг сайжруулна,хортон шавьжинд тэсвэртэй
- Шим тэжээлээр баялаг
- Орчны бохирдолгүй байгальд ээлтэй.






Нөхөн сэргээлтийн бэлтгэл үе шатыг хангах үүднээс үржүүлгийн талбай бий болгох үүднээс 6х27.той хүлэмжийг ашиглалтанд оруулж, хайлаас үрээр тарилт хийсэн.





## 7. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТАЙЛАН

Байгаль орчин эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS 5914-2008, Уул уурхай үйлдвэрлэлийн үйл ажиллагаар эвдэрсэн газрын ангилал MNS 5915-2008, Газар шурооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт,хадгалалт MNS 5916-2008,Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS 5917-2008, стандартуудыг баримтлан ажилласан.

Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг Монгол улсын Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 12 сарын 29-ний өдөр баталсан “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачилал” -ын дагуу хийж гүйцэтгэсэн.

Өгөөмөр шороон ордны MV-008866, MV-001329 төслийн талбайд 2025 онд Байгаль орчны менежментийн батлагдсан төлөвлөгөөгөөр төслийн талбайд нийт техникийн нөхөн сэргээлт 8.7 га, Биологийн нөхөн сэргээлт 6.0 га. Талбайд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн бөгөөд тайлант онд техникийн нөхөн сэргээлт **2025 оны 10 дугаар сарын 15-ны байдлаар** 8.0 га талбайд гүйцэтгэж биологийн нөхөн сэргээлт 25.4 га талбайд гүйцэтгэн хүлээлгэн өгхөд бэлтгэсэн байна.

**Хүснэгт.7 Нөхөн сэргээлтийн тайлан**

| Д/д | Нөхөн сэргээлтийн зорилт | Нөхөн сэргээх арга хэмжээ | Байгаль орчныг хамгаалахад авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | Арга хэмжээний цар хүрээ | Нийт зардал | Хэрэгжүүлэх хугацаа давтамж | Зураг |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Техникийн нөхөн сэргээлт | Дүүргэлт | 2025 онд нийт 8.0 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн. | Төслийн талбайд | | Олборлолтын хугацаанд |  |
| 2 | Биологийн нөхөн сэргээлт | Бэлчээрийн олон наст тарих | 6 төрлийн бэлчээрийн олон настийг биологийн нөхөн сэргээлтэнд ашигласан. /Нийт-25.4 га/ | Төлөвлөгөөний дагуух | | Жилийн турш |  |
| | | | | | Нийт дүн | | 62.000 |

## НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТАЙЛАН

**Техникийн нөхөн сэргээлтийн бэлтгэл үе шат**

- Дүүргэлт хийх
- түрэлт,хэлбэршүүлэх
